



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 262

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид сэргээн засварлаж ашиглах боломжгүй болсон 18,753,179.40 (арван найман сая долоон зуун тавин гурван мянга нэг зуун далан есөн төгрөг дөчин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий 1 ширхэг микроавтобусыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэн, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнгийн захирал Т.Төрмөнх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0001985

ийн өмчийн бодлого, зорилго, үүрэг, мөн чанарыг  
3 оны 6 дугаар сарын 08-ны өдөр /2017 он/  
дугаар тогтоолын хавсгал

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

| Д/д      | Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар         | Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ                                                                             | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг | Сэргээн босгоглын зардал | Хуудлах дээд үнийн санал |
|----------|---------------------------------------------------------------------------|-----------------------------------|-----------------|------------------------------------------------------------------------------------------|-----------------------|----------------|--------------------------|--------------------------|
| /төгрөг/ |                                                                           |                                   |                 |                                                                                          |                       |                |                          |                          |
| 1        | Хьюндай Старекс, УБО 14-18, суудлын автобус хөдөлгүүр:128815, арал:104158 | 1998/1998                         | 109,100         | 18,753,179.40                                                                            | 18,753,179.40         | -              |                          | 1,000,000.00             |
| Нийт дүн |                                                                           |                                   |                 | 18,753,179.40                                                                            | 18,753,179.40         | -              | -                        | 1,000,000.00             |
|          |                                                                           |                                   |                 | (арван найман сая долоон зуун тавин гурван мянга нэг зуун далан есөн төгрөг дөчин мөнгө) |                       |                |                          | (нэг сая)                |